



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

MONTHLY BULLETIN OF STATISTICS

2018/2



www.nso.mn govisumber.nso.mn www.1212.mn



ГАРЧИГ

- I. Нийгмийн байдал.....
- II. Нийгмийн даатгал, халамж.....
- III. Эрүүл мэнд
- IV. Гэмт хэрэг
- V. Үнэ.....
- VI. Төсөв.....
- VII. Хөдөө аж ахуй
- VIII. Аж үйлдвэр
- IX. Цаг уур.....
- Хавсралт.....



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал




I. Нийгмийн байдал

I.1 Ажил хайгч иргэд

Тайлант сарын эцэст Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэд 524, үүнээс ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 272 байгаагийн 154 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 10 буюу 3.8 хувиар, өссөн үзүүлэлттэй байна.

Хоёрдугаар сард Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт 3 ажлын байрны захиалга иржээ. Тайлант сард ажилд зуучлагдсан иргэд байхгүй байна.

Зураг I.1. Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэн, жил бүрийн тайлант сарын эцэст



Ажил хайгч ажилгүй иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 15-24 насны 45, 25-34 насны 57, 35-44 насны 35, 45-54 насны 31, 55 түүнээс дээш насны 7 иргэн байна.


I.2 Ердийн хөдөлгөөн

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2018 оны 2 сарын байдлаар 76 эх амаржиж, 76 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 22 буюу 40.7 хувиар, төрсөн хүүхдийн тоо 21 буюу 38.2 хувиар тус тус өссөн байна.

Нас баралт 15, бүртгүүлсэн гэр бүл 14, цуцалсан гэр бүл 2 байгаа нь өмнөх оны мөн үеэс нас баралт 2 буюу 11.8 хувиар буурч, бүртгүүлсэн гэр бүл 3 буюу 27.3 хувиар өсч, цуцалсан гэр бүл 4 буюу 66.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд үрчлэгдсэн хүүхэд 1 байна. Шилжилт хөдөлгөөний мэдээгээр 118 хүн шилжин ирж, 71 хүн шилжин явсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал шилжин ирэлт 28.3 хувиар өсч, шилжин явалт 42.7 хувиар буурчээ.



Зураг 1.2. Төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 2 сарын байдлаар



II. Нийгмийн даатгал, халамж

II.1 Нийгмийн даатгал

2018 оны 2 сарын байдлаар Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн орлого 1310.8 сая төгрөг, зарлага 1952.6 сая төгрөг болсон байна.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт 123.8 хувьтай, зарлагын гүйцэтгэл 114.8 хувьтай байна.

II.2 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2018 оны 2 сарын байдлаар 2611 хүнд 328.9 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамж хүртэгсэд 317 хүн буюу 10.8 хувиар буурсан, олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж 170.8 сая төгрөг буюу 23.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 2018 оны 2 сарын байдлаар 1303 хүн хамруулж 158.2 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 591 хүн буюу 80.3 хувиар өссөн, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 36.8 сая төгрөг буюу 30.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжид 2018 оны 2 сарын байдлаар 1308 хүн хамруулж 170.8 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 908 хүн буюу 41.0 хувь, олгосон халамж үйлчилгээ, хөнгөлөлт, тусламж 52.6 сая төгрөг буюу 23.5 хувь буурсан үзүүлэлттэй байна.


II.3 Дундаж цалин

Аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны 2 дугаар сарын мэдээгээр 183 байгууллагын 4359 даатгуулагч иргэн, үүнээс 331 нь сайн дурын даатгуулагч байна. Ажиллагсдын дундаж цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 11 аж ахуйн нэгж, байгууллагын 337 даатгуулагчийн дундаж цалин 871.1 мянган төгрөг, төсөвт 52 байгууллагын 1492 даатгуулагчийн дундаж цалин 687.6 мянган төгрөг, 2 Хувьцаат Компаний 606 даатгуулагчийн дундаж цалин 1181.1



мянган төгрөг, 106 ХХКомпаний 1510 даатгуулагчийн дундаж цалин 1388.5 мянган төгрөг, бусад 12 аж ахуйн нэгж байгууллагын 83 даатгуулагчийн дундаж цалин 433.0 мянган төгрөг боллоо.

Зураг II.1. Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо, 2018 оны 2 сарын байдлаар




III. Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2018 оны 2 сарын байдлаар 82 эх амаржиж, 2017 оны мөн үетэй харьцуулахад 19 буюу 30.1 хувиар нэмэгдсэн байна. Амьд төрсөн хүүхэд 82 үүнээс 32 нь хүү, 50 нь охин байна. Өмнөх оны мөн үеэс төрсөн хүүхэдийн тоо 19 тохиолдлоор нэмэгдсэн байна.

0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл , 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл болон эхийн эндэгдэл гараагүй.


Зураг III.1. Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн 2 сарын байдлаар



Халдварт өвчин 2 сарын байдлаар 10000 хүн амд 23.4 буюу өмнөх оны мөн үеэс 39.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




Зураг III.2.Нас баралт, жил бүрийн 2 сарын байдлаар



Он гарсаар давхардсан тоогоор 16530 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 1269 хүнээр буюу 7.1 хувиар буурсан, 787 өвчтөн эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 95 хүнээр буюу 10.8 хувиар буурсан байна.

2018 оны 2 сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 1116, халдварт өвчин 39 бүртгэгдсэн байна.


Зураг III.3.Амьгүй төрсөн хүүхэд болон нялхасын эндэгдэл, жил бүрийн 2 сарын байдлаар



IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2018 оны 2 сарын байдлаар 33 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7 буюу 17.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг IV.1.Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 2 сарын байдлаар



Өмнөх оны мөн үеэс нийт гэмт хэргийн тоо буурахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Илрээгүй гэмт хэрэг 22 байгаа нь өмнөх оны мөн үеэс 5 дахин өссөн. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 48.7 болсон нь өмнөх оны мөн үеэс 49 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн улмаас 12 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс 57.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг IV.2.Гэмт хэргийн ангилал, жил бүрийн 2 сарын байдлаар




Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2018 оны 2 сарын байдлаар 115.0 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 14.0 сая төг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирлын хэмжээ 2 дахин өссөн, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 6.0 сая төгрөг буюу 30.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2018 оны 2 сарын байдлаар давхардсан тоогоор 85 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 24 хүнээр буюу 22.0 хувиар буурсан байна.



Зураг IV.3. Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо жил бүрийн 2 сарын байдлаар



V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хүснэгт V.1. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 2 дугаар сард, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2018.II}{2017.II}$	$\frac{2018.II}{2017.XII}$
Ерөнхий индекс	105.1	101.6
Хүнсний бараа, ундаа, ус	106.4	103.9
Согтууруулах ундаа, тамхи	107.1	102.3
Хувцас, бөс бараа, гутал	101.1	101.1
Орон сууц, ус, цахилгаан, түлш	118.7	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	104.7	100.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	101.3	100.0
Тээвэр	114.0	104.4
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	99.9	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	98.3	100.0
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	99.3	100.0
Бусад бараа, үйлчилгээ	104.0	100.0

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны сарын мэдээ



VI. Төсөв санхүү, банк


2018 оны 2 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 2281.5 сая төгрөг, гүйцэтгэлээр 2262.1 сая төгрөг болж 99.1 хувийн биелэлттэй байна.

Аймгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөө 3011.4 сая төгрөг, гүйцэтгэлээр 2273.3 сая төгрөг болж 75.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

2018 оны 2 сарын байдлаар авлагын үлдэгдэл 17.3 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 50.0 сая төгрөг байна.




Зураг VI.1.Орон нутгийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн 2 сарын байдлаар , сая төгрөгөөр



VII. Мал аж ахуй


Аймгийн хэмжээнд 2018 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 201476 хээлтэгч малаас 2 сард 605 хээлтэгч мал төллөж өмнөх оны мөн үеийнхээс 8.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 2018 оны 2 сарын байдлаар 6012 толгой том мал зүй бусаар хорогдсон байна. Өмнөх оны мөн үед том малын хорогдол 279 байсан болно.

Зураг VII.1.Төллөсөн хээлтэгч, жил бүрийн 2 сарын байдлаар, толгойгоор





Зураг VII.2.Хорогдсон хээлтэгч, жил бүрийн 2 сарын байдлаар, толгойгоор



VIII. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2018 оны 2 сарын байдлаар 5168.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 273.9 сая төгрөг буюу 5.6 хувиар, оны үнээр 5770.0 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 547.4 сая төгрөг буюу 10.5 хувиар өслөө.

Шивээ-Овоо ХК нь нийт бүтээгдэхүүний 93.6 хувь буюу 4.8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт борлуулалтын 94.3 хувь буюу 5.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.

Зураг VIII.1.Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар, жил бүрийн 1 сарын байдлаар , сая төгрөгөөр





III. 2-р сарын 1-нээс 2-р сарын 28-ныг хүртлэх өнгөрсөн сарын цаг агаарын тойм мэдээ

Хур тунадас: Энэ сард 1, 8, 28-ны өдрүүдэд цас орж, нийт 0,8 мм тунадас унасан. Ихэнх хугацаанд 1 см зузаан цасан бүрхүүлтэй.

Салхи: 1, 6, 8-12, 26, 28-ны өдрүүдэд салхи зарим газраар түр зуур 10-12 м/сек хүрч ширүүссэн. Бусад хугацаанд салхи секундэд 3-8 метр байсан.


Агаарын температур: Өнгөрсөн сарын агаарын температур 1-р арав хоног, 11, 14, 16, 19-21-ний өдрүүдэд шөнөдөө 24-29 градус хүйтэн, өдөртөө 12-17 градус хүйтэн, 24-28-ныг хүртэл шөнөдөө 13-18 градус, өдөртөө 1-6 хүйтэн, бусад хугацаанд шөнөдөө 18-23 градус өдөртөө 7-12 байсан байна. Өнгөрсөн сарын хамгийн дулаан нь 25-ны өдөр -0,9 градус хүйтэн, хамгийн хүйтэн нь 2-ны шөнө -28,6 градус хүйтэн байсан.

ГУРАВДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ


Энэ сард агаарын дундаж температур нь Говьсүмбэр аймгийн нутгаар 5-10 градус хүйтэн байдаг ба ихэнх нутгаар олон жилийн дунджаас 0.5-1.0 градусаар дулаан байна.

Нэгдүгээр арав хоногийн эхэн болон дунд үе, хоёрдугаар арав хоногийн эхээр бага зэрэг хүйтэрч шөнөдөө 19-24 градус, өдөртөө 3-8 градус хүйтэн байна. Нэг болон хоёрдугаар арав хоногийн сүүлчээр хүйтний эрч суларч шөнөдөө 6-11 градус хүйтэн, өдөртөө 1 градус дулаанаас 4 градус хүйтэн байна. Харин гуравдугаар арав хоногт дулаарч шөнөдөө 0-5 градус хүйтэн, өдөртөө 16-21 градус дулаан байна. Энэ сард олон жилийн дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй. Хоёрдугаар арав хоногийн сүүлээр зарим газраар бага зэргийн цас, гуравдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар хур тунадас орох төлөвтэй.

Нэг болон хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлээр зарим газраар 12-14 м/с, хоёр болон гуравдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар 16-18 м/с хүртэл ширүүсч шороон ба цасан шуурга шуурах төлөвтэй.



3 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв



3 дугаар сард орох хур тунадасны урьдчилсан төлөв



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 2 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 II	2018 II	$\frac{2018 II}{2017 II} \%$
Нийгмийн статистик				
Амьд төрсөн хүүхэд	хүүхэд	63	82	130.2
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	хүн	262	272	103.8
Халдварт өвчнөөр өвчлөгсөд	хүн	28	39	139.3
Бүртгэгдсэн гэмт хэрэг	хүн	40	33	82.5
Эдийн засгийн статистик				
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	2543.5	1075.3	100.4
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	2320.2	920.2	100.5
Авлага	сая.төг	29.0	17.3	65.5
Өглөг	сая.төг	43.1	33.9	110.1
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	сая.төг	9615.5	5168.8	53.7
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт	сая.төг	9946.4	4931.5	49.6
Төллөсөн хээлтэгч	толгой	660	605	91.7
Гарсан төл	толгой	662	606	91.5
Хорогдсон төл	толгой	78	96	123.1
Бойжсон төл	толгой	584	510	87.3
Том малын зүй бусын хорогдол	толгой	279	6012	*



I.1 АЖЛЫН БАЙРНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2017 II	2018 II	$\frac{2018 II}{2017 II} \%$
Ажил хайгч иргэд, сарын эцэст	376	524	139.3
Үүнээс: эмэгтэй	212	307	144.8
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	262	272	103.8
Үүнээс: эмэгтэй	139	154	110.8
Ажлын байрны захиалга	42	3	*
Ажилд зүүчлагдсан иргэд	14	0	*
Үүнээс: эмэгтэй	5	0	*

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ

I.2 ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 2 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2017 II	2018 II	$\frac{2018 II}{2017 II} \%$
Амаржсан эх	54	76	140.7
Төрсөн хүүхэд	55	76	138.2
Үрчлэгдсэн хүүхэд	1	1	-
Бүртгүүлсэн гэр бүл	11	14	127.3
Цуцалсан гэр бүл	6	2	33.3
Нас баралт	17	15	88.2
Шилжин ирсэн	92	118	128.3
Шилжин явсан	124	71	57.3

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээ

II.1 ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн 2 сарын байдлаар

Сангийн төрөл	2017 II	2018 II	$\frac{2018 II}{2017 II} \%$
ЭМНД-ын сангийн орлого, сая.төг	1544.2	1310.7	84.9
ЭМНД-ын сангийн зарлага, сая.төг	1612.3	1952.6	121.1

Эх үүсвэр: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн мэдээ



II.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, жил бүрийн 2 сарын байдлаар , сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 II		2018 II		$\frac{2018 II}{2017 II} \%$	
	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн
Нийгмийн халамжийн сангийн дүн	2928	344.8	2611	328.9	89.2	95.4
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	712	121.4	1303	158.2	183.0	130.3
Халамжийн тэтгэвэр	217	64.8	219	62.2	100.9	96.0
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	495	56.6	1084	96.0	219.0	169.6
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж	2216	223.4	1308	170.7	59.0	76.4
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	605	57.0	23	1.9	*	*
Насны хишиг	0	0	561	48.4	*	*
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	38	2.3	47	3.4	123.7	147.8
Нийгмийн халамжийн үйлчилгээ	379	6.8	0	0	*	*
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт тусламж мөнгөн тусламж	234	24.8	217	27.2	92.7	109.6
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	5	1.7	5	1.7	100.0	100.0
Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	955	130.8	1016	136.6	106.4	104.4

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ



III.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 2 сарын байдлаар

Үзүүлэлт	2017 II	2018 II	$\frac{2018 II}{2017 II} \%$
Төрсөн эх	63	82	130.2
Амьд төрсөн хүүхэд	63	82	130.2
Эрэгтэй	33	32	97.0
Эмэгтэй	30	50	166.7
Амьгүй төрсөн хүүхэд	0	0	*
Нийт нас баралт	16	9	56.3
Эмнэлгийн нас баралт	2	3	150.0
Хоног болоогүй нас баралт	2	0	*
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	0	*
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	1	0	*
Эмчлэгдсэн өвчтөн	882	787	89.2
Амбулаторийн үзлэг	17799	16530	92.9
Халдварт өвчин	28	39	139.2

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газрын мэдээ

IV.1 ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ , жил бүрийн 2 сарын байдлаар , төрлөөр

Үзүүлэлт	2017 II	2018 II	$\frac{2018 II}{2017 II} \%$
Бүртгэгдсэн гэмт хэрэг	40	33	-17.5
Хүний амьд явах эрхийн эсрэг, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	19	14	-26.3
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	16	13	-18.8
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	0	2	2 нэгж
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1	0	*
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	0	0	*



Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	3	2	-66.6
Бусад гэмт хэрэг	0	0	*
Гэмт хэрэгт <u>холбогдог</u>сод	51	17	-66.7
15 хүртэлх насны	0	0	*
16-34 насны	31	11	-64.5
35 ба түүнээс дээш насны	20	6	*
Боловсрол – Дээд	10	1	*
Боловсрол - Тусгай дунд	3	1	*
Боловсрол – Бүрэн дунд	14	9	*
Боловсрол – Бүрэн бус дунд	15	4	*
Боловсрол – Бага	3	2	*
Боловсролгүй	6	0	*
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн	6	0	*
Ажилгүй иргэд үйлдсэн	22	14	*
Эмэгтэй хүн оролцсон	4	4	*
Хүүхэд оролцсон	4	1	*
Бүлгээр үйлдсэн	4	1	*
Согтуугаар үйлдсэн	14	7	*
Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдал	40	33	17.5
Гудамж талбай, олон нийтийн газар	9	7	*
<u>Гэмт хэргийн улмаас нас барсан</u>	0	1	*
<u>Гэмт хэргийн улмаас гэмтсэн</u>	28	12	*
Учирсан хохирол / сая.төг /	53	115	2 дахин
Нөхөн төлүүлсэн хохирол / сая.төг /	20.0	14.0	*

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтсийн мэдээ

VI.1 ТӨСВИЙН ОРЛОГО, үзүүлэлтүүдээр, жил бүрийн 2 сарын байдлаар , сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 II	2018 II	$\frac{2018 II}{2017 II} \%$
Нийт орлого	2543.5	2262.1	99.1
Урсгал орлого	857.4	772.6	90.1
Татварын орлого	736.8	610.8	82.9
Татварын бус орлого	120.7	161.9	134.1
Тусламжийн орлого	1656.1	1489.4	89.9

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ



VI.2 ТӨСВИЙН ЗАРЛАГА, үзүүлэлтүүдээр, жил бүрийн 2 сарын байдлаар , сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 II	2018 II	$\frac{2018 II}{2017 II} \%$
Нийт зарлага	2320.2	2273.3	98.0
Урсгал зардал	2276.9	2059.9	90.1
Хөрөнгийн зардал	43.3	213.4	*

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VI.3 ТӨСВИЙН ӨГЛӨГ, АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, үзүүлэлтүүдээр, жил бүрийн 2 сарын байдлаар , сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 II	2018 II	$\frac{2018 II}{2017 II} \%$
Авлага	29.0	17.3	59.6
Өглөг	43.1	50.0	116.0
Төсөвт байгууллагын тоо	49	49	100.0
Төсөвт байгууллагын ажиллагсад	783	783	100.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VII.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жил бүрийн 2 сарын байдлаар

Төрөл	2017 II	2018 II	$\frac{2018 II}{2017 II} \%$
Бүгд	660	605	*
Ингэ	0	0	*
Гүү	0	2	*
Үнээ	88	53	*
Эм хонь	428	368	*
Эм ямаа	144	182	*

VII.2 ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ сумдаар, жил бүрийн 2 сарын байдлаар

Сумд	2017 II	2018 II	$\frac{2018 II}{2017 II} \%$
Дүн	660	605	*
<u>Баянтал</u>	53	165	*
Сүмбэр	607	370	*
<u>Шивээговь</u>	0	70	*



VII.3 БОЙЖСОН ТӨЛ, төлийн төрлөөр, жил бүрийн 2 сарын байдлаар

Төрөл	2017 II	2018 II	$\frac{2018 II}{2017 II} \%$
Бүгд	584	510	*
Ботго	0	0	*
Унага	0	2	*
Тугал	83	47	*
Хурга	376	318	*
Ишиг	125	143	*

VII.4 БОЙЖСОН ТӨЛ, сумдаар, жил бүрийн 2 сарын байдлаар

Сумд	2017 II	2018 II	$\frac{2018 II}{2017 II} \%$
Дүн	584	510	*
<u>Баянтал</u>	51	129	*
Сүмбэр	533	317	*
<u>Шивээговь</u>	0	64	*

VII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн 2 сарын байдлаар

Төрөл	2017 II	2018 II	$\frac{2018 II}{2017 II} \%$
Бүгд	279	6012	*
Тэмээ	0	0	*
Адуу	2	297	*
Үхэр	14	422	*
Хонь	68	1847	*
Ямаа	195	3446	*

VII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумдаар, жил бүрийн 2 сарын байдлаар

Сумд	2017 II	2018 II	$\frac{2018 II}{2017 II} \%$
Дүн	279	6012	*
<u>Баянтал</u>	132	639	*
Сүмбэр	147	5109	*
<u>Шивээговь</u>	0	264	*



VII.7 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн 2 сарын байдлаар

Төрөл	2017 II	2018 II	$\frac{2018 II}{2017 II} \%$
Бүгд	28	1196	*
Тэмээ	0	0	*
Адуу	0	77	*
Үхэр	0	117	*
Хонь	10	594	*
Ямаа	18	408	*

VII.8 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, сумдаар, жил бүрийн 2 сарын байдлаар

Сумд	2017 II	2018 II	$\frac{2018 II}{2017 II} \%$
Дүн	28	1196	*
<u>Баянтал</u>	5	128	*
Сүмбэр	23	1005	*
<u>Шивээговь</u>	0	63	*

VIII.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт жил бүрийн 2 сарын байдлаар , сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 II	2018 II	$\frac{2018 II}{2017 II} \%$
Нийт	4718.9	4931.5	104.5
Нүүрс олборлолт	4423.4	4600.5	104.0
Ус ариутгал, усан хангамж	598.9	978.8	163.4
Цахилгаан, хий дулаан үйлдвэрлэл	278.7	322.4	115.7

VIII.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, жил бүрийн 2 сарын байдлаар , сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 II	2018 II	$\frac{2018 II}{2017 II} \%$
Нийт	9946.4	10744.2	108.0
Нүүрс борлуулалт	9366.4	10044.2	107.2
Боловсруулах үйлдвэр	26.4	31.4	118.9
Цахилгаан, дулаан эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	553.6	668.6	120.7



VIII.3 Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үзүүлэлтүүд, Шивээ-Овоо ХК жил бүрийн 2 сарын байдлаар

Үзүүлэлт	2017 II	2018 II	$\frac{2018 II}{2017 II} \%$
Нүүрс борлуулалт /үнийн дүнгээр, сая.төг/	4423.4	4600.5	104.0
Нүүрс олборлолт /үнийн дүнгээр, сая.төг/	4411.1	4092.0	92.7
Нүүрс гаргалт /биет хэмжээ, мян.тн/	214.1	181.1	87.3
Ажиллагсад	567	541	95.4

E-мэйл хаяг:

Вэб хаяг:

Мэдээллийн сангийн хаяг:

Утас:

govisumber@nso.mngovisumber.nso.mnwww.1212.mn

70543222, 70543017